

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт
НДЕГ	Нийгмийн даатгалын Ерөнхий газар
ЭХМК	Эмнэлэг хөдөлмөрийн магадлах комисс
ТБОНӨХБАҮХАТХ	Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил Үйлчилгээ худалдан авах тухай хууль
ХХОАТ	Хувь хүний орлогын албан татвар
НДШ	Нийгмийн даатгалын шимтгэл

Агуулга

Аудитын гэрчилгээ	3
Аудитын тайлан.....	5
2.1. Оршил	5
2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага	5
2.3. Аудитад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт	5
2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин	6
2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ	6
2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал.....	7
2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар	7
2.8. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд	7
2.10. Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга	9
2.11. Аудитаар хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн.....	10
2.12. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал	13
2.13. Шилэн дансны мэдээлэл.....	13
2.14. Өмнөх аудитаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт	14
2.15. Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл.....	15
Менежментийн захидал	16
Аудит хийгдсэн санхүүгийн тайлан.....	20
1.1 Аудит хийгдсэн санхүүгийн байдлын тайлан	20
1.2 Аудит хийгдсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	21
1.3 Аудит хийгдсэн мөнгөн гүйлгээний тайлан	22
1.4 Аудит хийгдсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	23
1.5 Аудит хийгдсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	23
1.6 Аудит хийгдсэн нэмэлт санхүүжилтийн тайлан.....	25



**БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

64101 Баянхонгор аймаг,
Баянхонгор сум, Номгон баг
Утас, факс 7044 2584
E-mail: bayankhongor@audit.gov.mn

Г БАЯНХОНГОР АЙМГИЙН НИЙГМИЙН
ДААТГАЛЫН ХЭЛТСИЙН ДАРГЫН ҮҮРЭГ
ГҮЙЦЭТГЭГЧ Д.МӨНХБАТ ТАНАА

2020.03.25 № 1/315

танай _____ -ны № _____ -т

Г Аудитын гэрчилгээ 7

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.2-т заасны дагуу Баянхонгор аймгийн Нийгмийн даатгалын хэлтсийн 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн нэгтгэсэн тайлан, тодруулгад санхүүгийн тайлангийн аудит хийв.

Зөрчилгүй санал дүгнэлт

Баянхонгор аймгийн Нийгмийн даатгалын хэлтсийн 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт болон мөнгөн гүйлгээний тайланг материаллаг зүйлсийн хувьд Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон холбогдох стандартад нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлсэн тул зөрчилгүй санал дүгнэлт гаргаж байна.

Санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар Баянхонгор аймгийн Нийгмийн даатгалын хэлтсийн 2019 оны жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайлан дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус салбарт мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, программ хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.

D:\бичиг хэрэг 2020-Албан тоот А4\

005020264

Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.


Үүрэг хариуцлага

Баянхонгор аймгийн Нийгмийн даатгалын хэлтэс нь Төсвийн тухай хуулийн 26 дугаар зүйлд заасны дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Нягтлан бодох бүртгэлийн болон Улсын секторын нягтлан бодох олон улсын стандарт, түүнтэй нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж, жилийн эцсийн санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Б.МӨНХБАТ



D:\бичиг хэрэг 2020-Албан тоот А4\

2.1. Оршил

Баянхонгор аймгийн Нийгмийн даатгалын хэлтсийн 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүн, дүгнэлтийг Нийгмийн даатгалын хэлтсийн даргын үүрэг гүйцэтгэгч Д.Мөнхбат танд танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц асуудал, залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчил, тодруулга зэрэг аудитын үр дүн, аудитын дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Аудитын дүнд үндэслэсэн үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэл, тайлагнал, дотоод хяналтын системийг боловсронгуй болгох зөвлөмжүүдийг Менежментийн захидалд тусгасан болно.

2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 15.2, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.2-д заасны дагуу Баянхонгор аймгийн Нийгмийн даатгалын хэлтсийн 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болгосон санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Баянхонгор аймгийн Нийгмийн даатгалын хэлтсийн 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэл Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн гаргасан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн төвлөрүүлэн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2020 оны 03 дугаар сарын 18-наас 2020 оны 03 дугаар сарын 23-ны хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2020 оны 03 дугаар сарын 25-ны өдөр эцэслэн баталгаажуулж, төсвийн захирагчид хүргүүлэхээр төлөвлөн, Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын ахлах аудитор Б.Должмаа, аудитор Н.Бүнчинсүрэн нар хариуцаж хэрэгжүүлэв.

Баянхонгор аймгийн Нийгмийн даатгалын хэлтсийн 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Баянхонгор аймаг дахь төрийн аудитын газарт 2020 оны 03 дугаар сарын 04-ны өдөр ирүүлж, аудит хийлгэх тухай хүсэлтийг 2020 оны 01 дүгээр сарын 16-ны өдрийн 16 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

2.3. Аудитад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт

АДБОУС, АОУС, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчимд тулгуурласан Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайланд аудит хийх журам, төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайлангийн аудитад баримтлах ерөнхий чиглэл, арга зүйг мөрдөн ажиллав.

Дээрх стандарт, зарчим, журамд нийцүүлж аудитын үе шатны ажлыг гүйцэтгэж, холбогдох ажлын баримт материалаар баталгаажуулсан болно.

2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин

Баянхонгор аймгийн Нийгмийн даатгалын хэлтсийн үйл ажиллагааны эрхэм зорилго нь "Даатгуулагчийнхаа итгэл найдвар, сэтгэл ханамжаар үнэлэгдэх нийгмийн даатгалын үйлчилгээг хүргэх"-д оршино.

Баянхонгор аймгийн Нийгмийн даатгалын хэлтэс нь 2019 оны үйл ажиллагааны чиглэлийг "Танд ойрхон найрсаг үйлчилгээ" гэж тодорхойлжээ.

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- ✓ Цахим архивын системийг нэвтрүүлэх журмыг мөрдсөн.
- ✓ Засгийн газрын 2019 оны 26 дугаар тогтоолоор Нийгмийн даатгалын сангаас тэтгэвэр авагч болон цэргийн тэтгэвэр авагчийн тэтгэврийг 27.0-30.0 мянган төгрөгөөр нэмэгдүүлсэн.
- ✓ Өндөр настны тэтгэвэр тогтоолох иргэдийн дундаж цалинг тооцохдоо сүүлийн 20 жилийн дараалсан 5 жилийн дунджаар тооцдог байсныг 6 жилийн цалингийн дунджаас тооцож олгох болсон байна.
- ✓ Цэргийн албан хаагчийн тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуульд өөрчлөлт орж, цагдаагийн дадлагажигчаар ажилласан хугацааг цэргийн албанд ажилласан хугацаанд оруулж тооцдог, энгийн өндөр настны тэтгэвэр тогтоолоход цэргийн сургуульд суралцсан хугацааг иргэний байгууллагад ажилласан хугацаа руу шилжүүлэн тооцдог болсон.
- ✓ НДЕГ-аас салбарын хэмжээнд мөрдөх "Нийгмийн даатгалын байгууллагын ёс зүйн зөвлөлийн ажиллах журам"-ыг баталж, мөрдөж эхэлсэн байна.

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн эрхлэх асуудлын хүрээний 1 байгууллага, нэгж 2019 оны санхүүгийн тайландаа аудит хийж баталгаажуулахаас 1 байгууллага аудитад хамрагдсан байна.

Төрийн аудитын байгууллагаас эрх асуудлын хүрээний байгууллагад санхүүгийн тайлангийн аудит хийсэн хэлбэрийг дараах хүснэгтээр үзүүлэв.

№	Байгууллагын ангилал	Санхүүгийн тайлангийн аудит хийсэн хэлбэр				
		Санал дүгнэлт гаргасан	Түүвэрлэсэн	Итгэл үзүүлсэн	Гэрээгээр хийлгэсэн	Аудитад хамрагдаагүй
1	Төсвийн шууд захирагч	1				
2	ТБӨӨААН					
	Дүн	1				

2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа, дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан болно.

Баянхонгор аймгийн Нийгмийн даатгалын хэлтсийн мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь Сангийн яамнаас хэрэгжүүлж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцсэн байна.

Санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаанд ашиглаж байгаа мэдээллийн технологи, бүртгэл мэдээллийн системийн үйл ажиллагаатай танилцан түүний нарийн төвөгтэй байдлыг үнэлэхэд 47 оноотой үнэлэгдсэн тул мэдээллийн технологийн мэргэжилтнийг аудитад татан оролцуулах шаардлагагүй гэж үзэж аудитыг томилогдсон аудитор гүйцэтгэлээ.

Баянхонгор аймгийн Нийгмийн даатгалын хэлтэс нь Нийгмийн даатгалын цогц программ хангамж ашигладаг байна.

Баянхонгор аймгийн Нийгмийн даатгалын хэлтсийн дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд дунд гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөгүй байна.

2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал

Аудитаар Баянхонгор аймгийн Нийгмийн даатгалын хэлтсийн бэлтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд байгууллагын гадаад дотоод орчин, дотоод хяналтыг судлан, эрсдэлтэй асуудлыг илрүүлж, үнэллээ.

Аудитыг төлөвлөх үе шатанд эрсдэлийн үнэлгээний урьдчилсан горим хэрэгжүүлэн 41 эрсдэлтэй асуудал тодорхойлж, эрсдэлийн үнэлгээний дүнд үндэслэн 31 асуудалд нарийвчилсан горим сорил хэрэгжүүлэхээр төлөвлөж баталгаажуулсан болно.

2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар

Аудитыг төлөвлөх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 1320, АОУС 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд 2018 оны санхүүгийн нэгтгэсэн тайлангийн нийт зардал тэрбум төгрөгөөс дээш үнийн дүнтэй тул 0.05 хувиар буюу 37233.5 мянган төгрөгөөр тооцов.

Гүйцэтгэлийн үе шатанд материаллаг байдлын түвшинг 2019 оны жилийн эцсийн санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлын 0.05 хувиар буюу 43583.8 мянган төгрөгөөр тооцсон байна.

Гүйцэтгэлийн шатанд материаллаг байдлын суурь төлөвлөлтийн шатанд тооцсон материаллаг байдлаас 6350.3 мянган төгрөгөөр өссөн нь төлөвлөлтийн шатанд материаллаг байдлын суурийг 2018 оны санхүүгийн үр дүнгийн тайлангаас тооцсонтой холбоотой байна.

Аудитыг төлөвлөх үе шатны материаллаг байдлын түвшинг Б201, аудитыг гүйцэтгэх үе шатны материаллаг байдлын түвшинг В401 маягтаар тус тус баримтжуулан баталгаажуулав.

2.8. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд

Баянхонгор аймгийн Нийгмийн даатгалын хэлтсийн 2019 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 1165930.4 мянган төгрөгөөр буюу 59.9 хувиар өссөн нь мөнгөн хөрөнгийн үлдэгдэл 1410741.5 мянган төгрөгөөр өссөнтэй холбоотой байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	817,852.87	2,228,594.36	1,410,741.50
Авлага	431,711.29	431,577.31	(133.98)
Урьдчилгаа	350.46	350.46	-
Бараа материал	17,444.78	20,814.85	3,370.07
Үндсэн хөрөнгө	850,642.11	860,177.00	9,534.89
Хуримтлагдсан элэгдэл	(174,011.50)	(431,943.54)	(257,932.05)
Нийт хөрөнгө	1,943,990.01	3,109,570.44	1,165,580.43
Өр төлбөр	219,837.89	276,844.69	57,006.80
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	1,724,152.12	2,832,725.76	1,108,573.64
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	1,943,990.01	3,109,570.44	1,165,580.43

Мөнгөн хөрөнгийн талаар

Харилцах дансны үлдэгдэл оны эцэст 2228594,3 мянган төгрөг болж, өмнөх оноос 1410741.5 мянган төгрөгөөр өссөн нь сар бүрийн эхэнд тэтгэвэр, тэтгэмж олгож байгаатай холбоотойгоор 2020 оны 01 дүгээр сарын тэтгэвэр, тэтгэмжийн санхүүжилт арилжааны банканд үлдэгдлээр байгаагаас шалтгаалсан байна.

Тус байгууллага Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8 дахь "Төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх" заалтыг хэрэгжүүлж ажиллаагүй оны эцэст 33776.4 мянган төгрөгийн байгууллагаас авах, 393889.9 мянган төгрөгийн нийгмийн даатгалын шимтгэлийн авлагатай, тэтгэмжийн даатгалын сангаас олгох тэтгэмжийн 99882.8 мянга, илүү төлсөн шимтгэлийн 155190.2 мянган төгрөгийн өглөгтэй ажилласан байна.

Авлагын талаар

Нийгмийн даатгалын сан:

Оны эхэнд нийгмийн даатгалын шимтгэлийн авлагын 386122.1 мянган төгрөгийн үлдэгдэлтэй байснаас оны эцэст 7767.8 мянган төгрөгөөр нэмэгдэж, 393889.9 мянган төгрөг болсон байна.

Бусад авлагын үлдэгдэл оны эхэнд 41360.5 мянган төгрөг байснаас тайлант онд 7584.0 мянган төгрөгөөр буурч 33776.4 мянган төгрөг болсон байна.

Нийгмийн даатгалын хэлтсийн үйл ажиллагаа:

Оны эхэнд татварын албанаас авах авлага 317.7 мянга, хувь хүмүүсээс авах авлага 3910.9 мянга байсан ба татварын албаны авлага барагдаж хувь хүмүүсээс авах авлага барагдаагүй байна. Энэ нь дарга асан Ц.Сэмжиддоржтой холбоотой авлага байна. Мөн оны эхэнд цалингийн урьдчилгааны 350.5 мянган төгрөгийн үлдэгдэлтэй байсан ба тайлант онд барагдаагүй байна. Энэ нь сангийн нягтлан бодогчоор ажиллаж байсан Дэмбэрэл 118.1 мянга, Баян-Овоо сумын нийгмийн даатгалын байцаагчаар ажиллаж байсан Сарантуяа 231.4 мянга төгрөгийн цалингийн урьдчилгаа байна.

Бараа материалын талаар

Бараа материал дансны үлдэгдэл өмнөх оноос 3720.1 мянган төгрөгөөр нэмэгдэж, 21164.8 мянган төгрөгийн үлдэгдэлтэй байгаа ба энэ нь бичиг хэргийн материал 660.5 мянга, сэлбэг хэрэгсэл 4232.6 мянга, аж ахуйн материал 713.5 мянган төгрөгөөр тус тус нэмэгдсэнтэй холбоотой байна.

Үндсэн хөрөнгийн талаар

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл өмнөх оноос 9534.9 мянган төгрөгөөр нэмэгдэж оны эцэст 860177.0 мянган төгрөг болсон нь Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын даргын 2019.12.17-ны өдрийн А-1/4240 дугаар тушаалаар 5463.7 мянган төгрөгийн үндсэн хөрөнгө акталсан, Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2019.12.17-ны а-1/4239 тоот тушаалаар 11400.0 мянган төгрөгийн үндсэн хөрөнгө НДЕГ-аас шилжүүлэн авсантай холбоотой байна.

Өглөгийн талаар

Нийгмийн даатгалын сан: ХЧТАТэтгэмжийн 1870.4 мянга, жирэмсэн болон амаржсаны тэтгэмжийн 98012.4 мянга, илүү төлсөн нийгмийн даатгалын шимтгэлийн өглөг 155190.2 мянга, даатгуулагч, ажил олгогчтой холбоотой 21297.4 мянга, нийт 276370.4 мянган төгрөгийн өглөгтэй байгаа нь өмнөх оноос 58718.0 мянган төгрөгөөр өссөн ба энэ нь оны эцэст тэтгэмжийн өглөг 155190.2 мянган төгрөгөөр нэмэгдсэн, өмнөх оны илүү төлсөн шимтгэл 34432.6 мянга, бусад өглөг 6732.1 мянган төгрөгөөр буурсантай холбоотой байна.

Нийгмийн даатгалын хэлтсийн үйл ажиллагаа:

Тайлант оны эхэнд 2185.3 мянган төгрөгийн өглөгтэй байснаас 2135.3 мянган төгрөгийн өглөгийг барагдуулж 50.0 мянган төгрөгийн хувь хүнд өгөх өглөгийн үлдэгдэлтэй байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 2833149.8 мянган төгрөг болж 1108997.7 мянган төгрөгөөр өссөн ба 1100757.9 мянган төгрөг нь тайлант үеийн үр дүн, 8239.7 мянган төгрөгөөр өссөн нь өмнөх оны нийгмийн даатгалын шимтгэлийн тайланд төрлийн кодын засвар хийснээс ажил олгогчийн нийгмийн даатгалын шимтгэлийн өглөг, авлага үүссэнтэй холбоотой байна.

2.10. Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн төвлөрүүлэн захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Тайлант онд төсвийн төвлөрүүлэн захирагчийн хэрэгжүүлэх 2 хөтөлбөрт 6 арга хэмжээний зардалд зориулан 47073401.9 мянган төгрөгийн төсөв батлагдаж, улсын төсвөөс 33237835.1 мянга, нийгмийн даатгалын шимтгэлийн орлогоор 13835566.8 мянган төгрөг оруулахаар төлөвлөсөн ба улсын төсвөөс авах санхүүжилтийг 1187835.1 мянган төгрөгийг дутуу олгож, шимтгэлийн орлогыг 3805186.6 мянган төгрөгөөр давуулан биелүүлсэн байна.

Батлагдсан төсвийг 17949.9 мянган төгрөгөөр хэтрүүлсэн нь Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1 -т заасны дагуу тэтгэвэр, тэтгэмжийг олгосонтой холбоотой байна. Тайлант онд тэтгэврийн зардал 234947.7 мянга, оршуулгын тэтгэмж 10000.0 мянган төгрөгөөр хэмнэгдсэн бол ажилгүйдлийн тэтгэмж 74803.7 мянга, ҮОМШӨ-ний тэтгэвэр, тэтгэмж 5420.3 мянга, ХЧТАТэтгэмж 19807.9 мянга, жирэмсний болон амаржсаны тэтгэмж 166415.1 мянган төгрөгөөр тус тус хэтэрсэнтэй холбоотой байна.

Баянхонгор аймгийн Нийгмийн даатгалын хэлтэс өөрийн орлогын төлөвлөгөөгүй ажилладаг бөгөөд НДЕГ-аас 635025.6 мянган төгрөгийн төсөв батлагдсаныг бүрэн зарцуулсан байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 4.5-д харуулав.

Нэмэлт төсөв: Нэмэлт санхүүжилтийн дансанд НДЕГ-аас ахмадын тэтгэмжийн санхүүжилт 2208.0 мянга, халаалтын зардлын санхүүжилт 3680.0 мянга, бүсийн сургалтын

санхүүжилт 16500.0 мянга, ЭХМК-ийн зөвлөгөөний замын зардал 56.0, Засаг даргын нөөц хөрөнгөөс ЭХМК-ын зардалд 3300.0 мянган төгрөг олгож, нийт 25744.0 мянган төгрөгийн орлого орж зарцуулагдсан байна. Мөн арилжааны банкаар архивын орлого 462.7 мянган төгрөг орсноос 462.5 мянган төгрөгийг төвлөрүүлсэн байна.

2.11. Аудитаар хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн

Аудитыг төлөвлөх үе шатанд эрсдэлийн үнэлгээний урьдчилсан горим хэрэгжүүлэн 41 эрсдэлтэй асуудал тодорхойлж, эрсдэлийн үнэлгээний дүнд үндэслэн 31 асуудалд нарийвчилсан горим сорил хэрэгжүүлэхээр төлөвлөж баталгаажуулсан болно.

Эрсдэлийн үнэлгээний дүнд үндэслэн аудитын 7 чиглэлээр аудитын 41 горим сорил гүйцэтгэж, үнэлэхэд 11 асуудлыг алдаа, зөрчилтөйд тооцож, 30 асуудлыг алдаа, зөрчилд тооцохгүй гэж шийдвэрлэсэнээс гадна 1 асуудлыг аудитын явцад санхүүгийн тайланд залруулга хийлгэлээ.

Аудитын явцад хийсэн залруулгын талаарх мэдээллийг В30103 маягтаар нэгтгэж, баримтжуулсан болно.

Үүнээс: Залруулгын ангилал

№	Залруулгын товч утга	Мөнгөн дүн (сая төгрөгөөр)	Ангилал			
			Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлттэй холбоотой	Тайлант хугацаанд гарсан нягтлан бодох бүртгэлийн тооцооллын алдаа	Өмнөх тайлант хугацаанд гарсан нягтлан бодох бүртгэлийн тооцооллын алдаа	Нягтлан бодох бүртгэлийн тооцооллын өөрчлөлттэй холбоотой
1.	Оны эцэст 270.9 мянган төгрөгийн үйлдвэрчний эвлэлийн, 153.1 мянган төгрөгийн ХХОАТ-ын өглөгтэй байхад санхүүгийн тайланд өглөгөөр тусгаагүй байна.	0.4		0.4		
	Дүн	0.4		0.4		

Аудитаар цалингийн цэстийг тулган шалгаж, цалингаас суутган шилжүүлсэн ХХОАТ, үйлдвэрчний эвлэлийн өглөгийн тооцоог тулгахад үйлдвэрчний эвлэлийн өглөг 270.9 мянга, ХХОАТ-ын өглөг 153.1 мянган төгрөг байхад санхүүгийн тайланд өглөгөөр тусгаагүй зөрчил илэрлээ.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.4 дэх "Аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага, нягтлан бодогч нь үйлдвэрлэл, үйлчилгээний шат дамжлага, аж ахуйн үйл ажиллагааны хүрээнд гарсан хөрөнгө, эх үүсвэрийн хөдлөл, өөрчлөлт бүрийг анхан шатны баримтад бичгээр болон цахимаар бичилт хийж баталгаажуулна", 14 дүгээр зүйлийн 14.4 дэх "Нягтлан бодох бүртгэлд дараах зүйлсийг заавал бүртгэнэ: 14.4.2.бүх хөрөнгө, хөрөнгө оруулалт, авлага" гэсэн заалтуудыг зөрчсөн байгаа тул аудитын явцад санхүүгийн тайланд залруулав.

Аудитын явцад илрүүлсэн залруулаагүй алдаа, зөрчилтэй асуудлыг В501 маягтаар нэгтгэж, баримтжуулсан бөгөөд байгууллагын удирдлага болон холбогдох албан тушаалтнуудад танилцуулж, баталгаажуулсан.

Залруулаагүй алдаа, зөрчилтэй асуудлыг ангилсан байдал /сая.төг/

№	Шийдэл	Тоо	Дүн	Тайлбар
1	Зөвлөмж өгсөн	5	16.53	
2	Төлбөрийн акт тогтоосон	4	13.31	
3	Албан шаардлага өгсөн	1	0.35	
4	Сахилгын шийтгэл ногдуулахаар шилжүүлсэн	0	0.00	
5	Хууль хяналтын байгууллагад асуудлыг шилжүүлсэн	0	0.00	
	Дүн	10	30.19	

2.11.1 Зөвлөмж өгөхөөс бусад хэлбэрээр шийдвэрлэсэн алдаа, зөрчилтэй асуудал

Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчилтэй асуудлаас зөвлөмж өгөх асуудлыг Менежментийн захидалд оруулж, бусад хэлбэрээр шийдсэн алдаа, зөрчилтэй асуудлын дэлгэрэнгүйг дараах заалтад хураангуйлан тэмдэглэв. Үүнд:

2.11.1.1 Зардлын данстай холбоотой асуудал

Нийгмийн даатгалын хэлтсийн даргын 2019.04.24-ны өдрийн А/14 дугаар тушаалаар аймгийн аварга шалгаруулах болон Нийгмийн хамгааллын ажилтны өдрийг тохиолдуулан зохион байгуулж байгаа гар бөмбөгийн тэмцээнд оролцоход зориулан хэлтсийн албан хаагч бүрд тус бүр 30.0 мянган төгрөгийн үнэтэй футболкыг худалдан авч 1020.0 мянган төгрөгийн зардлыг мэдээлэл сурталчилгааны зардлаас олгож, төсвийг зориулалт бусаар зарцуулсан зөрчил илэрлээ.

Энэ нь Үнэн зөв байдал, Хэмжилт гэсэн батламж мэдэгдэлтэй нийцэхгүйгээс гадна Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8-т “Төсвийг үр ашигтай хэмнэлттэй байхаар төлөвлөж зарцуулах”, Сангийн сайдын 2014 оны 55 дугаар тушаалаар батлагдсан “Эдийн засгийн ангилал батлах тухай” 6 дугаар хавсралтын “Мэдээлэл сурталчилгааны зардалд төрийн ажил, үйлчилгээг олон нийтэд мэдээлэх, таниулах сурталчлах үйл ажиллагаатай холбогдон гарах зардлыг энэ ангилалд бүртгэнэ” гэсэн заалтыг тус тус зөрчсөн байна

Шийдвэрлэсэн: Төлбөрийн акт тогтоов.

2.11.1.2 Зардлын данстай холбоотой асуудал

Бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр буюу гэрээгээр гүйцэтгүүлэх ажил үйлчилгээний зардалд гэрээт ажилтны цалинг баталж, 4680.0 төгрөг баталснаас гүйцэтгэлээр гэрээт ажилтанд 1-3-р сард 1091.4 төгрөг олгож, 3588.6 мянган төгрөг хэмнэгдсэнийг оны эцэст ажиллагсад үр дүнгийн урамшуулал олгосон байна.

Энэ нь Үнэн зөв байдал, Хэмжилт гэсэн батламж мэдэгдэлтэй нийцэхгүйгээс гадна Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5 дахь “Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах”, Сангийн сайдын 2014 оны 55 дугаар тушаалаар батлагдсан “Эдийн засгийн ангилал батлах тухай” 6 дугаар хавсралтын “Төрийн өмнөөс гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөрийн зардалд хууль тогтоомжийн дагуу төр хариуцахаар заасан чиг үүрэг, ажил үйлчилгээг гуравдагч этгээдээр гэрээний үндсэн дээр гүйцэтгүүлэхэд гарах зардлыг энэ ангилалд бүртгэнэ” гэсэн заалтыг тус тус зөрчсөн байна

Шийдвэрлэсэн: Төлбөрийн акт тогтоов.



2.11.1.3 Балансын данстай холбоотой асуудал

“Тоонот хонгор” ХХК-д 2019.07.16-ний өдөр 584.1 мянган төгрөг шилжүүлж 350.0 мянган төгрөгийн өртөг бүхий бичиг хэргийн шүүгээ, 234.1 мянган төгрөгийн бичгийн хавтас авсан боловч бичиг хэргийн шүүгээг хөрөнгөд орлогоор бүртгээгүй байна.

Энэ нь Иж бүрэн, Үнэн зөв байдал гэсэн батламж мэдэгдэлтэй нийцэхгүйгээс гадна Нягтлан бодох бүртгэлийн хуулийн 13 дугаар зүйлийн 13.4 дэх “Аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага, нягтлан бодогч нь үйлдвэрлэл, үйлчилгээний шат дамжлага, аж ахуйн үйл ажиллагааны хүрээнд гарсан хөрөнгө, эх үүсвэрийн хөдлөл, өөрчлөлт бүрийг анхан шатны баримтад бичгээр болон цахимаар бичилт хийж баталгаажуулна”, 14 дүгээр зүйлийн 14.4.2-т “Нягтлан бодох бүртгэлд бүх хөрөнгө, хөрөнгө оруулалт, авлага зүйлсийг заавал бүртгэнэ” гэсэн заалтыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн: Төсвийн хөрөнгөөр бэлтгэсэн 350.0 мянган төгрөгийн шүүгээг 2020 онд үндсэн хөрөнгөд орлогоор бүртгэх албан шаардлага өгөв.

2.11.1.4. Зардлын данстай холбоотой асуудал

Түүврийн аргаар 2019 онд тэтгэвэр тогтоолгосон аймгийн төвийн даатгуулагчийн мэдээллийг шалгахад ажил олгогчоос нэр бүхий 32 даатгуулагчийн цалин, хөлсийг 22 /тэтгэвэр тогтоолгосны дараа ажиллаж байгаа ажилтан/ кодоор мэдээлэхээр байхад 01 /Аж ахуйн нэгж байгууллагын ажилтан/ кодоор мэдээлснээс нийгмийн даатгалын санд даатгуулагч, ажил олгогчоос 6,881.3 мянган төгрөгийн нийгмийн даатгалын шимтгэл илүү төлсөн байна.

Энэ нь Иж бүрэн байх, Үнэн зөв байдал гэсэн батламж мэдэгдэлтэй нийцэхгүйгээс гадна Нийгмийн даатгалын тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.6 дахь “Ажил олгогч, иргэнтэй байгуулсан хөдөлмөрийн гэрээ болон Иргэний хуулийн 343, 359 дүгээр зүйлд заасан гэрээний дагуу ажиллаж байгаа тэтгэвэр авагч энэ хуулийн 3 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн 3, 5 дахь заалтад зааснаас бусад төрлийн даатгалд албан журмаар даатгуулна. Үндсэн ажлаас гадуур байгуулсан хөдөлмөрийн гэрээ болон Иргэний хуулийн 343, 359 дүгээр зүйлд заасан гэрээний дагуу давхар ажил эрхэлж байгаа Монгол Улсын иргэн, гадаадын иргэн, харьяалалгүй хүн энэ хуулийн 3 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн 5 дахь заалтад зааснаас бусад төрлийн даатгалд албан журмаар даатгуулна”, Сангийн сайд, Хөдөлмөр нийгмийн хамгааллын сайдын 2017 оны 211/А112 тоот хамтарсан тушаалын хавсралтыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн: Төлбөрийн акт тогтоов.

2.11.1.5. Зардлын данстай холбоотой асуудал

Ажилгүйдлийн тэтгэмж авсан 306 даатгуулагчаас 1,500,000 төгрөгөөс дээш ажилгүйдлийн тэтгэмж авсан 82 иргэний тэтгэмж олголтыг түүврийн аргаар шалгахад “Цогцэций энерги ресурс” ХХК-аас ажлаас чөлөөлөгдсөн ВЭ82060177 регистрийн дугаартай Ч.Баттөрийн нэг өдрийн дундаж цалинг тооцохдоо 2019 оны 3 дугаар сарын цалин 3,200,000 төгрөг байхад 320,000 төгрөгөөр бодсоноос шалтгаалж, даатгуулагчид 1,839,057 төгрөгийн ажилгүйдлийн тэтгэмж дутуу олгосон байна.

Энэ нь Хэмжилт, Үнэн зөв байдал гэсэн батламж мэдэгдэлтэй нийцэхгүйгээс гадна Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн 2016 оны 22 дугаар тогтоолын хавсралтаар баталсан “Ажилгүйдлийн даатгалын сангаас тэтгэмж олгох журам”-ын 4.5 дахь “Энэ журмын 3.5-д заасан тохиолдолд ажилгүйдлийн тэтгэмж бодох цалин хөлс, орлогын дунджийг тодорхойлохдоо тухайн даатгуулагчийн сүүлийн 3 сард бүтэн ажиллаж авсан хөдөлмөрийн хөлс, түүнтэй адилтгах орлогыг үндэслэн тооцох ба ажилд буцаж орсноос хойш цалин авсан нийт хугацаа нь 3 сард хүрэхгүй бол хүүхдээ асрах чөлөө олгосон тушаал, шийдвэр гарсан сарын өмнөх шимтгэл төлсөн хугацааны цалинг оруулан тооцно” гэснийг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн: Төлбөрийн акт тогтоов.

2.12. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал

Авлага барагдуулах арга хэмжээг авч хэрэгжүүлж, өмнөх онуудын авлагыг барагдуулж ажилласан эсэх, НДЕГ-аас ирүүлсэн төсвийн хуваарь Э-тайланд оруулсан төсвийн хуваариас зөрүүтэй байгаа зэргийг тодруулж, шалгах шаардлагатай.

Өмнөх аудитаар гарсан алдаа зөрчил дахин давтагдсан, насжилт өндөртэй авлага бууруулах, түүнийг барагдуулах арга хэмжээ авч ажиллаагүй байгаа тул энэ талаар НДЕГ-ийн ерөнхийлөн захирагчийн тайланд зөвлөмж болгон оруулж, буруутай албан тушаалтнуудад хариуцлага тооцуулах саналтай байна.

2.13. Шилэн дансны мэдээлэл

Баянхонгор аймгийн Нийгмийн даатгалын хэлтэс нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийг шилэн дансны нэгдсэн хуудаст оруулсан байдлыг шалгахад дараах байдалтай байна.

Нийгмийн даатгалын сан:

Байгууллагын батлагдсан орон тоонд орсон өөрчлөлтийг 10 дугаар сард, Таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий худалдан авсан бараа, ажил үйлчилгээний нэр, санхүүжилтийн хэмжээ, нийлүүлэгчийн нэр, хаягийн мэдээллийг 9, 10 дугаар сард, төсвийн байгууллагын батлагдсан төсөв, гүйцэтгэл, хэтрэлт хэмнэлтийн шалтгаан тайлбарыг 7 дугаар сар, хагас жил, 3 дугаар улирлаар тус тус хугацаа хоцроож мэдээлсэн байна.

д/д	Хугацаа	Төрөл	Удаа	Хугацаанд оруулсан	Хугацаа хоцроосон	Хугацаа болоогүй
1	Бүтэн жил	11	11	3	3	5
2	Хагас жил	4	4	1	3	
3	Улирал бүр	1	4	2	2	
4	Сар бүр	3	36	34	2	
5	Тухай бүр	8	96	94	2	
	Нийт	27	151	134	12	5

Нийгмийн даатгалын хэлтэс:

Шилэн дансны нэгдсэн системд мэдээллийг үнэн зөв байршуулсан эсэхийг шалгахад төсвийн байгууллагын батлагдсан төсөв, гүйцэтгэл, хэтрэлт хэмнэлтийн шалтгаан тайлбарыг 1-р улирал, 7,8 дугаар сард, тухайн жилийн төсөвт орсон нэмэлт өөрчлөлтийг 6,7,8 дугаар сард, цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг 7 дугаар сард, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах, өр, авлага үүсгэсэн аливаа шийдвэрийг 6,7 дугаар сард, байгууллагын батлагдсан орон тоонд орсон өөрчлөлтийг 7,8 дугаар сард тус тус хоцроосон байна.

д/д	Хугацаа	Төрөл	Удаа	Хугацаанд оруулсан	Хугацаа хоцроосон	Хугацаа болоогүй
1	Бүтэн жил	11	11	11		-
2	Хагас жил	4	4	4		
3	Улирал бүр	1	4	3	1	
4	Сар бүр	3	36	30	6	

5	Тухай бүр	8	96	89	7	
	Нийт	27	151	137	14	-

Цаашид Шилэн дансны тухай хуульд заасан мэдээллийг заасан хугацаанд оруулдаггүй алдааг давтан гаргахгүй байхад анхаарч ажиллах шаардлагатай байна.

2.14. Өмнөх аудитаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газраас 2018 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар 3 зөвлөмж өгсөн бөгөөд зөвлөмжийн хэрэгжилтийг шалгахад 1 зөвлөмжийг бүрэн хэрэгжүүлж, 2 зөвлөмжийг хэрэгжүүлээгүй, алдаа дахин давтагдсан ба зөвлөмжийн биелэлт 53.0 хувьтай байна. Иймд цаашид хяналтын байгууллагаас өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллах төлөвлөгөө гаргаж, зөвлөмжийг бүрэн хэрэгжүүлж ажиллах шаардлагатай байна.

Эдгээр зөвлөмжийн биелэлтийн талаарх мэдээллийг ажлын баримт материалд хадгалсан бөгөөд гүйцэтгэлийг аудитын явцад дахин нягталсан болно.

2.15. Санхүүгийн тайланд хийсэн аудитаар илэрсэн зөрчлийн нэгтгэл:

2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар нийт илэрсэн алдаа, зөрчлийн 1.3 хувь буюу 424.1 мянган төгрөгийн алдааг аудитын явцад залруулж, 43.5 хувь буюу 13310.0 мянган төгрөгийн зөрчилд хохирлыг барагдуулах төлбөрийн акт тогтоож, 1.1 хувь буюу 350.0 мянган төгрөгийн зөрчлийг арилгах албан шаардлага хүргүүлж, 54.1 хувь буюу 13530.0 мянган төгрөгийн зөрчлийг засах, давтан гаргахгүй байх зөвлөмж хүргүүлээ.

Төрийн аудитын байгууллагаас аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил түүний шийдвэрлэлийн байдлыг дор нэгтгэн үзүүлэв. Үүнд:

Залруулаагүй алдаа, зөрчлийн шийдвэрлэлт (сая төгрөг)

№	Байгууллагын ангилал	Үүнээс: Залруулаагүй алдаа, зөрчлийн шийдвэрлэлт											
		Залруулаагүй алдаа, зөрчил		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах санал		Хууль хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	ТТЗ	10	30.19	4	13.31	1	0.35	5	16.53	-	-	-	-
2	ТШЗ												
3	ТБӨААН												
	Дүн	10	30.19	4	13.31	1	0.35	5	16.53	-	-	-	-

2.16. Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл

Бид Баянхонгор аймгийн Нийгмийн даатгалын хэлтсийн 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланд аудит хийж, баталгаажуулах ажлыг АДБОУС-ын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

“Зөрчилгүй” дүгнэлт

Нийгмийн даатгалын хэлтсийн 2019 оны жилийн эцсийн нэгтгэсэн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлт болон бусад илчлэл тодруулгыг холбогдох хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 4.1.3 заалт, УСНББОУС-ын дагуу материаллаг байдлын хувьд үнэн зөв, бодитой илэрхийлсэн эсэхийг Аудитын гэрчилгээнд тодорхой дурдав.

Менежментийн захидал

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудит бүрийн төгсгөлд аудитаар илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг үйлчлүүлэгч, түүний удирдлагад зориулж бэлтгэдэг бөгөөд түүнд санхүү, нягтлан бодох бүртгэл, тайлагналын бодлого, үйл ажиллагаа, дотоод хяналтыг сайжруулах зөвлөмжийг тусгадаг.

Энэхүү менежментийн захидлын агуулга аудитын үр дүн, дүгнэлтээс урган гарсан болно. Санхүүгийн тайлан, бусад илчлэл тодруулгын талаар санал дүгнэлт гаргахад бидний бодлого, горим зориулагдсан.

